



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Б.АСРАЛТ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2021.03.25

№ 01/999

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ

Гаалийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Гаалийн ерөнхий газар 2020 онд үндсэн чиг үүргийн хүрээнд Бодлогын баримт бичгийн хүрээнд 7 арга хэмжээ, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 6 арга хэмжээ, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 16, тусгай чиг үүргийн 11 арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн биелэлт 98 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсөв захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ



## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,185,921.2	30,715,765.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,335,640.3	3,796,681.5
33	АВЛАГА	860,621.0	61,551.4
34	УРЬДЧИЛГАА	24,480,980.4	31,626.0
35	БАРАА МАТЕРИАЛ	4,508,679.5	4,388,063.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0	22,437,843.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	86,943,208.9	134,198,975.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	86,943,208.9	134,198,975.0
39200	Биет хөрөнгө	82,408,327.6	127,781,498.2
39300	Биет бус хөрөнгө	4,534,881.3	6,417,476.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	118,129,130.2	164,914,740.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	472,338.2	3,252,673.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	472,338.2	3,252,673.4
41300	Өглөг	472,338.2	3,252,673.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	117,656,792.0	161,662,066.9
51	Засгийн газрын хувь оролцоо	117,656,792.0	161,662,066.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	70,229,324.4	71,069,406.4
51200	Хуримтлагдсан үр дүн	41,320,068.5	84,485,261.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,107,399.0	6,107,399.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	118,129,130.2	164,914,740.2

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**  
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>117,276,023.2</b>	<b>107,631,938.2</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,857,184.3</b>	<b>16,527,821.7</b>
<b>120</b>	Нийтлэг татварын бус орлого	15,857,184.3	16,522,842.2
<b>13</b>	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	101,418,838.8	91,104,116.4
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>79,632,734.3</b>	<b>64,402,432.6</b>
<b>21</b>	УРСГАЛ ЗАРДАЛ	79,632,734.3	64,402,432.6
<b>210</b>	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,945,089.7	47,806,673.7
<b>2101</b>	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,099,018.2	25,131,287.8
<b>2102</b>	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,778,997.6	3,202,377.8
<b>2103</b>	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,279,061.2	2,246,622.9
<b>2104</b>	Хангамж, бараа материалын зардал	709,131.0	884,235.8
<b>2105</b>	Нормативт зардал	156,260.4	1,155,432.6
<b>2106</b>	Эд хогшил, урсгал засварын зардал	724,804.6	1,046,399.5
<b>2107</b>	Томилолт, зочны зардал	117,382.4	100,845.9
<b>2108</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,743,100.5	3,620,712.4
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	12,337,333.9	10,418,759.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,687,644.6</b>	<b>16,595,758.9</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>37,643,288.8</b>	<b>43,229,505.5</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>33,208,351.8</b>	<b>63,182.0</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>4,434,937.1</b>	<b>43,166,323.6</b>



**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	104,013,444.5	107,690,337.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,594,039.8	16,559,946.2
120	Нийтлэг татварын бус орлого	2,594,039.8	16,559,946.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	101,419,404.8	91,130,391.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,725,513.0	49,943,205.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,725,513.0	49,943,205.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,809,553.1	42,880,168.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,026,445.6	24,891,187.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,760,847.4	3,199,551.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,300,672.9	2,254,952.3
2104	Хангамж, бараа материалын зардал	583,385.0	811,989.7
2105	Нормативт зардал	1,186,386.0	832,492.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,078,619.0	3,608,658.6
2107	Томилолт, зочны зардал	138,179.1	80,908.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,960,336.7	5,131,140.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	774,681.4	2,069,286.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,915,959.9	7,063,037.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	66,287,931.5	57,747,132.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	65,789,816.2	55,286,091.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,789,816.2	55,286,091.0
2200	Дотоод эх үүсвэрээр	65,789,816.2	55,286,091.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-65,789,816.2	-55,286,091.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	498,115.3	2,461,041.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	837,525.0	1,335,640.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,335,640.3	3,796,681.5

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**  
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,214,309.8	0.0	113,214,309.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,545.0	0.0	7,545.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	113,221,854.9	0.0	113,221,854.9
9	Тайлант үеийн үр дүн	4,434,937.1	0.0	4,434,937.1
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,656,792.0	0.0	117,656,792.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,130.6	0.0	-1,130.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,655,661.3	0.0	117,655,661.3
17	Өмчид гарсан өөрчлөлт	840,082.0	0.0	840,082.0
19	Тайлант үеийн үр дүн	43,166,323.6	0.0	43,166,323.6
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	161,662,066.9	0.0	161,662,066.9



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>96,760,965,700.00</b>	<b>86,530,685,047.51</b>	<b>10,230,280,652.49</b>	<b>89.4</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>54,205,665,700.00</b>	<b>44,046,154,259.33</b>	<b>10,159,511,440.67</b>	<b>81.3</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>51,968,748,000.00</b>	<b>42,988,431,245.32</b>	<b>8,980,316,754.68</b>	<b>82.7</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>27,342,035,000.00</b>	<b>24,891,187,741.77</b>	<b>2,450,847,258.23</b>	<b>91.0</b>
Үндсэн цалин	15,171,326,100.00	13,882,661,023.56	1,288,665,076.44	91.5
Нэмэгдэл	8,238,555,400.00	7,241,770,494.02	996,784,905.98	87.9
Унаа хоолны хөнгөлөлт	1,129,293,500.00	965,650,292.66	163,643,207.34	85.5
Урамшуулал	2,802,860,000.00	2,801,105,931.53	1,754,068.47	99.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,619,502,900.00</b>	<b>3,199,551,932.64</b>	<b>419,950,967.36</b>	<b>88.4</b>
Тэтгэврийн даатгал	2,575,423,100.00	2,403,958,910.12	171,464,189.88	93.3
Тэтгэмжийн даатгал	260,375,600.00	198,992,048.13	61,383,551.87	76.4
ҮОМШӨ-ний даатгал	210,878,500.00	159,815,374.12	51,063,125.88	75.8
Ажилгүйдлийн даатгал	52,075,000.00	42,428,524.74	9,646,475.26	81.5
Эрүүл мэндийн даатгал	520,750,700.00	394,357,075.53	126,393,624.47	75.7
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>3,917,947,800.00</b>	<b>2,254,952,271.56</b>	<b>1,662,995,528.44</b>	<b>57.6</b>
Гэрэл, цахилгаан	2,023,103,900.00	1,153,743,181.16	869,360,718.84	57.0
Түлш, халаалт	1,192,916,600.00	625,561,900.26	567,354,699.74	52.4
Цэвэр, бохир ус	285,658,200.00	94,214,743.14	191,443,456.86	33.0
Байрны түрээс	416,269,100.00	381,432,447.00	34,836,653.00	91.6
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>918,725,500.00</b>	<b>819,598,738.63</b>	<b>99,126,761.37</b>	<b>89.2</b>
Бичиг хэрэг	113,796,100.00	106,859,400.00	6,936,700.00	93.9
Тээвэр, шатахуун	331,808,900.00	329,862,311.00	1,946,589.00	99.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	56,510,900.00	47,193,983.63	9,316,916.37	83.5
Ном, хэвлэл	95,465,000.00	49,097,500.00	46,367,500.00	51.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,295,200.00	19,162,280.00	24,132,920.00	44.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	277,849,400.00	267,423,264.00	10,426,136.00	96.2
<b>Нормативт зардал</b>	<b>986,410,300.00</b>	<b>832,492,320.00</b>	<b>153,917,980.00</b>	<b>84.4</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,382,000.00	8,092,120.00	289,880.00	96.5
Хоол, хүнс	33,175,000.00	32,773,700.00	401,300.00	98.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	944,853,300.00	791,626,500.00	153,226,800.00	83.8
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,646,471,100.00</b>	<b>4,208,114,146.88</b>	<b>438,356,953.12</b>	<b>90.6</b>
Багаж, техник, хэрэгсэл	1,394,733,200.00	1,216,550,966.77	178,182,233.23	87.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	733,127,300.00	697,298,067.00	35,829,233.00	95.1
Урсгал засвар	2,518,610,600.00	2,294,265,113.11	224,345,486.89	91.1
<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>187,272,500.00</b>	<b>80,908,565.00</b>	<b>106,363,935.00</b>	<b>43.2</b>



Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дотоод албан томилолт	187,272,500.00	80,908,565.00	106,363,935.00	43.2
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,908,951,700.00</b>	<b>5,155,658,583.61</b>	<b>2,753,293,116.39</b>	<b>65.2</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,092,193,800.00	4,532,140,276.55	2,560,053,523.45	63.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	22,442,000.00	12,195,000.00	10,247,000.00	54.3
Даатгалын үйлчилгээ	93,809,100.00	72,253,438.91	21,555,661.09	77.0
Тээврийн хэрэгслийн татвар	15,351,700.00	7,603,949.00	7,747,751.00	49.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,709,500.00	2,316,828.00	1,392,672.00	62.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	151,547,200.00	150,130,419.15	1,416,780.85	99.1
Газрын төлбөр	17,982,300.00	10,814,212.00	7,168,088.00	60.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	511,916,100.00	368,204,460.00	143,711,640.00	71.9
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,441,431,200.00</b>	<b>1,545,966,945.23</b>	<b>895,464,254.77</b>	<b>63.3</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	2,044,535,000.00	1,491,646,822.50	552,888,177.50	73.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	396,896,200.00	54,320,122.73	342,576,077.27	13.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,236,917,700.00</b>	<b>1,057,723,014.01</b>	<b>1,179,194,685.99</b>	<b>47.3</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>85,482,200.00</b>	<b>83,301,209.01</b>	<b>2,180,990.99</b>	<b>97.4</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	85,482,200.00	83,301,209.01	2,180,990.99	97.4
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,151,435,500.00</b>	<b>974,421,805.00</b>	<b>1,177,013,695.00</b>	<b>45.3</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,046,022,000.00	880,708,430.00	1,165,313,570.00	43.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	105,413,500.00	93,713,375.00	11,700,125.00	88.9
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>42,555,300,000.00</b>	<b>42,484,530,788.18</b>	<b>70,769,211.82</b>	<b>99.8</b>
Барилга байгууламж	16,653,600,000.00	16,648,440,788.18	5,159,211.82	100.0
Тоног төхөөрөмж	25,901,700,000.00	25,836,090,000.00	65,610,000.00	99.7
<b>ЗАРДЛЫГ</b>				
<b>САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>96,760,965,700.00</b>	<b>86,530,768,647.51</b>	<b>10,230,197,052.49</b>	<b>89.4</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>95,533,818,500.00</b>	<b>85,170,720,767.69</b>	<b>10,363,097,732.31</b>	<b>89.2</b>
Улсын төсвөөс санхүүжих	95,533,818,500.00	85,170,720,767.69	10,363,097,732.31	89.2
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,227,147,200.00</b>	<b>1,360,047,879.82</b>	<b>-132,900,679.82</b>	<b>110.8</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,227,147,200.00	1,360,047,879.82	-132,900,679.82	110.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	157,200.70	-157,200.70	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	240,800.70	-240,800.70	-
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1,622</b>	<b>1,438</b>	<b>184</b>	<b>88.6</b>
Удирдах ажилтан	68	68	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,245	1,034	211	83.0



Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үйлчлэх ажилтан	309	336	-27	108.7
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>1,622</b>	<b>1,438</b>	<b>184</b>	<b>88.7</b>
Төрийн тусгай албан хаагч	1,253	1,066	187	85.1
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	369	372	-3	100.8

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		
			452,697,500.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		355,597,500.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		111,169,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		11,040,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		11,040,400.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		94,794,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		94,794,400.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		11,335,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,335,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		238,427,800.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		189,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		189,150,000.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		49,277,800.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		26,275,000.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		23,002,800.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		97,100,000.00
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		97,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		97,100,000.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		452,697,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		452,697,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		38,935,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		175,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		194,051,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		44,130,600.00



### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Асралт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн шалгагдагч этгээдэд харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-аас 2021 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Л.Нямтөмөр гүйцэтгэв.

Гаалийн Ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/515а дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилго нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах;
- Бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх;
- Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх;
- Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Гаалийн ерөнхий газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гаалийн ерөнхий газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь 2020 онд 2 зорилтын 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.4 хувиар гүйцэтгэж, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хүрээнд харьяа газар, хэлтсийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 38 зөвлөмж өгч ажилласан байна.

Гаалийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” байна гэж үзлээ.

#### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн САГ-2021/02/СТА-ТТЗ



үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлаас 2 хувиар тооцож, 1,585.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлаас 2 хувиар тооцож, 1,288.0 сая төгрөгөөр тогтоов.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,335.6 сая, эцсийн үлдэгдэл 3,796.7 сая төгрөг болж, 2,461.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.05	0.05	-
Банканд байгаа бэлэн мөнгө	1,335.6	3,796.4	2,460.8
<b>Дүн</b>	<b>1,335.6</b>	<b>3,796.6</b>	<b>2,460.8</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 0.2 сая төгрөг арилжааны банкны харилцах дансанд, 3,212.0 сая төгрөг барьцаа дансанд, 584.4 сая төгрөг захиалагчийн техник хяналтын зардлын дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Дорнод аймаг дахь гаалийн газар и-баримтын цахим сайтад нийт худалдан авалтын 12.4 хувь буюу 31.9 сая төгрөгийг бүртгүүлээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс 1.0 сая төгрөгийн ХХОАТ суутгаж ажилласан;
- Дархан-Уул аймаг дахь гаалийн газар гаалийн улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагналыг олгохдоо ГЕГ-ын даргын тушаалын хавсралтаар хуваарилсан дүнгээс 8.1 сая төгрөгөөр хэтрүүлсэн;
- Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар ажлаас гарсан 5 ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын 1.0 сая төгрөгийн нөхөн олговрыг олгоогүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

#### 3.5.2. Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 860.6 сая, эцсийн үлдэгдэл 61.5 сая төгрөг болж, 799.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.4	0.5	-0.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	15.0	-	-15.0
Татаас, санхүүжилтийн авлага	0.3	-	-0.3
Бусад авлага	843.9	61.0	-782.9
<b>Дүн</b>	<b>860.6</b>	<b>61.5</b>	<b>-799.1</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 35.9 сая төгрөгийн дараах авлага байна.

Үүнд:

- Завхан аймаг дахь Арцсуурь гаалийн хороонд 2013-2015 онуудад үүссэн 9.6 сая төгрөгийн авлага нь гэрэл цахилгааны төлбөр;
- Гаалийн ерөнхий газарт 2009 оноос өмнө үүссэн 24.5 сая төгрөгийн авлага нь харилцагч байгууллагуудын мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын мэдээллийн санд байхгүй тул шийдвэрлэх боломжгүй болсон;



Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт 2000 оноос өмнө үүссэн харилцагч нас барсан шалтгаантай орон сууцны ашиглалтын төлбөрийн нийт 2.6 сая төгрөг нь шийдвэрлэх боломжгүй авлага байна.

Аудитын илрүүлэлт: Дорнод аймаг дахь гаалийн газар 0.9 сая төгрөгийн он дамжсан авлагын үлдэгдэлтэй ажилласан.

### 3.5.3. Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 24,481.0 сая, эцсийн үлдэгдэл 31.6 сая төгрөг болж, 24,449.4 сая төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	8,176.9	31.6	-8,145.3
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	16,304.1	-	-16,304.1
<b>Дүн</b>	<b>24,481.0</b>	<b>31.6</b>	<b>-24,449.4</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2020 онд үүссэн 31.6 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

- Гаалийн ерөнхий газрын 2021 оны 1 дүгээр улирлын хэвлэл захиалгын зардал 0.6 сая төгрөг;
- ГЕГ-ын дэргэдэх Үйлчилгээ, аж ахуйн албаны 2020 онд автомашины даатгалын зардалд шилжүүлсэн төлбөрийг сар, сараар зардлаар хүлээн зөвшөөрдөг үлдэгдэл 21.1 сая төгрөг;
- КОВИД-19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд халдварын голомтот бүсэд үүрэг гүйцэтгэж буй Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг боомтод ажиллаж буй албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах 9.9 сая төгрөгийн зардал.

### 3.5.4. Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 4,508.7 сая, эцсийн үлдэгдэл 4,388.1 сая төгрөг болж, 120.6 сая төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын	53.7	47.0	-6.7
Эм боох материал	0.03	0.1	0.07
Бэлэн бүтээгдэхүүн	537.7	968.7	431.0
Бичиг хэрэг	119.3	90.6	-28.7
Аж ахуйн материал	2,888.1	1,614.8	-1,273.3
Сэлбэг хэрэгсэл	39.5	42.3	2.8
Түлш, шатах тослох материал	99.3	117.5	18.2
Барилгын засварын материал	0.9	0.05	-0.85
Хүнсний материал	19.3	21.2	1.9
Бусад хангамжийн материал	654.0	1,382.7	728.7
Мал амьтад	96.7	102.9	-6.2
<b>Дүн</b>	<b>4,508.7</b>	<b>4,388.1</b>	<b>-120.6</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын /орон нутгийн/ хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 22,437.8 сая төгрөгийн ажил бүрэн дуусаагүй, бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна. Олон жил болж байгаа ашиглагч байгууллагад шилжүүлээгүй хөрөнгө оруулалт байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар тайлант оны түлш, халаалтын зардлын хэмнэлтийг оны эцэст татан төвлөрүүлэлгүйгээр нүүрс нөөцөлж авсан;



- Увс аймаг дахь гаалийн газар 2020 онд 4.3 сая төгрөгийн 2716 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүй, зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, тооцоог бодоогүй, хяналтгүйгээр зарцуулсан байна.

### 3.5.5. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 86,943.2 сая, эцсийн үлдэгдэл 134,198.9 сая төгрөг болж, 47,255.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	51,517.0	79,061.3	27,544.3
Тээврийн хэрэгсэл	1,571.2	2,642.8	1,071.6
Машин тоног төхөөрөмж	28,054.9	43,467.3	15,412.4
Тавилга эд хогшил	717.1	2,268.4	1,551.3
Түүх соёлын дурсгалт зүйлс	7.2	7.2	-
Дуусаагүй барилга байгууламж	204.8	-	-204.8
Номын фонд	37.4	55.2	17.8
Бусад үндсэн хөрөнгө	298.8	279.3	-19.5
Программ хангамж	104.1	788.4	684.3
Бусад биет бус хөрөнгө	4,430.7	5,629.1	1,198.4
<b>Дүн</b>	<b>86,943.2</b>	<b>134,199.0</b>	<b>47,255.9</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,108.1 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 55,429.1 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 893.9 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 314.2 сая, акталсан 1,900.0 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар БНХАУ-ын талаас 2016 оны 9 сард уурын зуух үнэ төлбөргүй барьж өгснийг данс бүртгэлд тусгаагүй;
- ГЕГ-ын дэргэдэх Үйлчилгээ аж ахуйн алба техник хяналтын зардлын 293.5 сая төгрөгийн өмнөх онуудын үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

### 3.5.6. Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 472.3 сая, эцсийн үлдэгдэл 3,252.6 сая төгрөг болж, 2,780.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	472.3	3,252.6	2,780.3	100
Ажилчидтай холбогдсон өглөг	0.02	0.02	-	0.3
Бараа үйлчилгээний зардлын зардал	2.8	9.1	6.3	-
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	434.5	-	-434.5	-
Бусад өглөг	35.0	3,243.5	3,208.5	99.7
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>472.3</b>	<b>3,252.6</b>	<b>2,780.3</b>	<b>100</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 3,212.0 сая төгрөгийн барьцаа, хугацаа хэтэрсэн 24.4 сая төгрөгийн өр байна. Үүнд:

- Горхи мэлхий хад амралтын газарт 2011 онд Нийслэлийн татварын газраас шалгалт хийж НӨАТ төлөөгүй шалтгаанаар 22.9 сая төгрөгийн акт тогтоосон нь Гаалийн байгууллага шийдвэрлэх боломжгүй өглөгөөр бүртгэсэн;

- Мөн харилцагч байгууллагуудын мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын мэдээллийн санд байхгүй шийдвэрлэх боломжгүй 1.5 сая төгрөгийн өглөг тус тус байна.

### 3.5.7. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 117,656.8 сая, эцсийн үлдэгдэл 161,662.1 сая төгрөг болж, 44,005.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал				
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	70,229.3	71,069.4	840.1	44.0
Хуримтлагдсан үр дүн	41,320.1	84,485.3	43,165.2	52.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,107.4	6,107.4	-	3.7
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-1.1	-1.1	-
<b>Дүн</b>	<b>117,656.8</b>	<b>161,662.1</b>	<b>44,005.3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 44,005.3 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай. Үүнд:

Засгийн газрын оруулсан капитал 71,069.4 сая төгрөг болж 840.1 сая төгрөгөөр өссөн нь Дорноговь аймгийн Сайншанд дахь гаалийн газрын лабораторийн барилгын өргөтгөл хийх газар, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар болон Өмнөговь аймгийн Гашуун сухайт дахь гаалийн газруудын дахин төлөвлөлттэй холбоотой шинээр авсан газрыг үнэлж бүртгэлд тусгасан байна.

Хуримтлагдсан үр дүн 84,485.3 сая төгрөг болж 43,165.2 сая төгрөгөөр өссөн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансны дүн 1.1 сая төгрөгөөр буурсан нь Өмнөговь аймгийн Шивээ хүрэн дэх гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрууд 2019 оны санхүүгийн тайланд аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу өмнөх үеийн үр дүнд залруулга хийсэн байна.

### 3.5.8. Орлогын данс

#### Туслах үйл ажиллагааны орлого

Тайлант онд 1,227.1 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого бүрдүүлж улсын төсөвт төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 1,360.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 110.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 8. Туслах үйл ажиллагааны орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	1,227.1	1,360.0	132.9	110.8
<b>Нийт дүн</b>	<b>1,227.1</b>	<b>1,360.0</b>	<b>132.9</b>	<b>110.8</b>

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 78,008.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,227.1 сая төгрөгөөр, нийт



зарлагыг 79,235.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 24,242.6 сая төгрөгөөр бууруулж 54,992.7 сая төгрөгөөр баталсан байна

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 54,992.7 сая төгрөгийн урсгал төсөв баталснаас 53,765.6 сая төгрөгийг улсын төсвөөс 1,227.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 48,193.2 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 1,360.0 сая төгрөг, нийт 49,553.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 44,046.2 сая төгрөгийг зарцуулж 5,507.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт урсгал зардлын гүйцэтгэл 44,046.2 сая төгрөг буюу 81.2 хувьтай байгаа нь дараах голлох шалтгаантай байна. Үүнд урсгал үйл ажиллагааны зардлын хүрээнд:

- Хөшгийн хөндий дэх Олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтад ороогүй тул тус онгоцны буудалд ажиллах нэмэлт орон тооны цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал болон урсгал зардалд нийт 1,883.2 сая төгрөг зарцуулагдаагүй;
- Гаалийн шинэчлэлийн хүрээнд Сангийн яамнаас Гаалийн байгууллагын төсөвт орон тоо нэмж шийдвэрлэсэн бөгөөд салбар лабораториудын тоног төхөөрөмж цар тахалтай холбоотой сонгон шалгаруулалт болон нийлүүлэлтийн хугацаа хойшилсонтой холбогдуулан дээрх орон тоогоор албан хаагчдын тоог нэмэгдүүлээгүй, үүнтэй холбоотой цалингийн зардал мөн Шуурхай удирдлагын төвийн барилга, Гаалийн төв лабораторийн барилгуудыг 2020 оны 4 дүгээр улиралд ашиглалтад хүлээлгэн өгсөн тул өмнөх улирлын ашиглалтын зардал гараагүй дутуу зарцуулагдсан;
- Мөн дээрх зардлуудаас гадна цар тахлын үед тэвчиж болох зардал /дотоод албан томилолт, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал гэх мэт/-уудыг зарцуулаагүй байна.

Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээнд 42,555.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 42,484.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 2,940.2 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд, захиалагчийн хяналтын дансанд 282.3 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжаар 30.6 сая, байгууллага болон гадаад төсөл хөтөлбөрөөс 130.4 сая, Засгийн газрын нөөц сангаас 53.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 194.1 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 18.0 сая, нийт 452.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс:

Сангийн сайдын 2020 оны 225 дугаар тушаалаар 194.1 сая төгрөг хуваарилагдсаныг ГЕГ-ын даргын 2020 оны А/236 тоот тушаалаар дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна.

1. ГЕГ-ын даргын 2019 оны А/298 тоот тушаалаар батлагдсан Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмын дагуу байгууллага хамт, олны урамшуулалд 86.5 сая төгрөг;
2. Ахмадын үйл ажиллагаа дэмжих урамшуулалд 15.0 сая төгрөг;
3. Нэг удаагийн тэтгэмж 3 хүнд 14.8 сая төгрөг /эмчилгээний зардал/;
4. Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил үйлчилгээний зардалд 72.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн шийдвэрээр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж сурталчлах зорилгоор” нийт 122.1 сая төгрөгийг УХШИГГ, БУГГ-уудад хуваарилан зарцуулсан байна. Засгийн газрын нөөц сангаас Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтод цар тахлын үед ажилласан 66 албан хаагчид нэг удаагийн шагнал урамшуулалд нийт 52.8 сая төгрөг, мөн Улсын онцгой комиссоос цар тахлын үед ажилласан 40 албан хаагчид нэг удаагийн шагнал урамшуулалд нийт 20.0 сая төгрөг, Дорноговь аймгийн Замын-Үүд дэх гаалийн газарт цар тахлын хандив Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газраас 0.5 сая төгрөг, бусад байгууллагуудаас 10.6 сая төгрөг, төсөл хөтөлбөрөөс 8.3 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд тус тус зарцуулж үлдсэн 23.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### **3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shitendans.gov.mn](http://www.shitendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Гаалийн ерөнхий газрын системийн хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээллийг байршуулаагүй зэрэг дараах зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Говь-Алтай аймаг дахь Бургастай гаалийн хороо шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 6, 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийг дутуу мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 орлого, зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 1 шийдвэрийг байршуулаагүй;
- Дорнод аймаг дахь гаалийн газар шилэн дансны цахим сайтад төсөв зарцуулсан, хөрөнгө актлуулсан шийдвэр дутуу байршуулсан;
- Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 148 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 13 мэдээллийг байршуулаагүй;
- Буянт-Ухаа дахь гаалийн газар шилэн дансны цахим системд 1-6 дугаар сарын 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогыг мэдээлээгүй, 120.3 сая төгрөгийн 17 ажил гүйлгээний худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг мэдээлээгүй;
- Өмнөговь аймаг дахь Гашуун сухайт гаалийн газар тус онд гарсан хагас, бүтэн жилийн өмчийн тооллогын тушаалыг, мөн хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг тухай бүрд нь мэдээлээгүй, шилэн дансны нэгдсэн цахим системд 15 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй, 5, 6, 8, 9, 10, 11, 12 дугаар саруудад 11 орлогын 1,235.9 сая төгрөгийн гүйлгээ, 6, 9, 10, 11, 12 дугаар саруудад 5 зарлагын 95.1 сая төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй зэрэг зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 88.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

### **3.9. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 21 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан, Орхон, Хөвсгөл, Өмнөговь аймгийн гаалийн газруудад орон нутаг дахь Төрийн аудитын газраас итгэл үзүүлж, Горхи мэлхий хад амралтын газар үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаас аудитад хамруулаагүй.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 13, “Хязгаарлалттай” 1 /Говь-Алтай аймгийн Бургастай дахь гаалийн хороо/ дүгнэлт өгсөн байна.



Аудитаар нийт 2,364.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,194.9 сая төгрөгийн 12 алдааг аудитын явцад залруулж, 9.1 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,096.9 сая төгрөгийн 13 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 63.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 31 зөвлөмжийг хүргүүллээ.

### **Залруулга**

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд 500.5 сая төгрөгийн дараах алдааг залруулав.

#### Буюнт-Ухаа дахь гаалийн газар:

- Үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 3.3 сая төгрөгийн гар чийдэнг орлогод авахдаа худалдан авснаар тайлагнасан;
- Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 39.3 сая төгрөгөөр илүү, НДШ-ийг 35.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Мөнгөн хөрөнгийн тайланд 56.3 сая төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд бүртгээгүй;
- Шатахууны үнийн хөнгөлөлтийн 0.9 сая төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгаагүй;

#### ГЕГ-ын дэргэдэх Үйлчилгээ, аж ахуйн алба:

- Мөнгөн хөрөнгийн тайланд 316.5 сая төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд бүртгээгүй;

#### ГЕГ-ын Санхүү хөрөнгө өрүүлэлтийн хэлтэс:

- Байрны түрээсийн 39.5 сая төгрөгийн зардлыг холбооны суваг дансанд бүртгэж зардал хооронд гүйлгэж зарцуулсан.

### **Албан шаардлага**

1. Буюнт-Ухаа дахь гаалийн газар тайлант хугацаанд шилэн дансны цахим системд 1-6 дугаар сарын 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогыг мэдээлээгүй, 120.3 сая төгрөгийн 17 ажил гүйлгээний худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

2. Гаалийн ерөнхий газар нь техник хяналтын зардлын 293.5 сая төгрөгийн өмнөх оны үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1 Балансын данстай холбоотой асуудал

###### 1.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,364.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,194.8 сая төгрөгийн 12 алдааг аудитын явцад залруулж, 9.1 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,096.9 сая төгрөгийн 13 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 63.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 31 зөвлөмж өгсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.7, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 14 дүгээр зүйлийн 14.4.2, Шилэн дансны тухай хууль, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалын 2, 6 дугаар хавсралт, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох журам”-ын 15 дахь заалт, ГЕГ-ын даргын 2014 оны А/201 дугаар тушаалаар баталсан “Гаалийн улсын байцаагчийн ажлын үр дүнг үнэлэх журам”-ын 3.5 дахь заалтыг тус тус зөрчиж, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 1.2 Эрсдэл:

Дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх;

###### 1.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах;

###### 1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилган, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b> 2020	<b>Аудитын нэр:</b>	<b>Гаалийн ерөнхий газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	<b>Аудитын код:</b> САГ-2021/02/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Гаалийн ерөнхий газар</b>		<b>Сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Техник хяналтын зардлын 293.5 сая төгрөгийн өмнөх онуудын үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.	293.5	Зөрчил арилгуулах албан шаардлага	ГЕГ-ын дэргэдэх Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга, Гаалийн улсын ахлах байцаагч	Ц.Отгонжаргал, А.Болор-Эрдэнэ
2	Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд 1-6 сарын 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогыг мэдээлээгүй, 120.3 сая төгрөгийн 17 ажил гүйлгээний худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг мэдээлээгүй байна.	-	Зөрчил арилгуулах албан шаардлага	Буянт-Ухаа Гаалийн газрын Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Баасандорж, Б.Урангоо
3	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,364.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,194.8 сая төгрөгийн алдааг залруулж, 9.1 сая төгрөгийн зөрчилд 2 акт, 1,096.9 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 63.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 31 зөвлөмж өглөө.	-	Зөвлөмж өгөх	ГЕГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Гаалийн улсын ахлах байцаагч	Д.Долгорсүрэн, Б.Орхонтуул
	<b>Дүн</b>	293.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 03 25 450/A0160057  
С.ЯТ-2021/02/СТА-113  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гаалийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Техник хяналтын зардлын 293,496.2 сая төгрөгийн 2019 оны үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Техник хяналтын зардлын зарцуулаагүй үлдэгдэл 293,496.2 (хоёр зуун ерэн гурван сая дөрвөн зуун ерэн зургаан мянга хоёр зуу) мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ГЕГ-ын дэргэдэх Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга Ц.Отгонжаргал, Гаалийн улсын ахлах байцаагч А Болор-Эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

Л.НЯМТӨМӨР





2021 03

25

451/АО160057  
СББ-2021/02/СТА-ТТЗ

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд 1-6 дугаар сарын 5 саяас дээш үнийн дүн бүхий орлого, 120,349.3 мянган төгрөгийн 17 ажил гүйлгээний худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, хуулийн хугацаанд нь бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт-Ухаа дахь Гаалийн газрын Захирал Г.Баасандорж, Ерөнхий нягтлан бодогч Б.Урангоо нарт даалгав.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

Л.НЯМТӨМӨР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

110.19.10.20/Bichig\_Khereg/Alban\_Shaardlaga/2021/03/20auditin\_Z-R\_Gazar/53\_Dokx

001080845